

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 11 дүгээр
сарын 01-ний өдөр

№ 30

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 дэх заалтад Банкны Төлөөлөн удирдах зөвлөл Банкны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.8 дахь заалтад Банкны Төлөөлөн удирдах зөвлөл Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хамарсан зохистой хяналтын тогтолцоог бүрдүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А-143 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтад Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны бодлого, стратеги, эрсдэл даах сонирхлыг тодорхойлох, банканд үр ашигтай шийдвэр гаргах эрх, үүргийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А-143 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад Гүйцэтгэх удирдлага нь Банкны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, ... бодлого, дүрэм, журам, зааврыг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах үүргийг хэрэгжүүлэхээр заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13.1 дэх заалтад Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах эрх, үүргийг хэрэгжүүлэхээр заасныг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, Банкны удирдлагын зүгээс танилцуулсан саналуудыг Төлөөлөн удирдах зөвлөл санал нэгтэйгээр хүлээн зөвшөөрсний дагуу, ИЙНХҮҮ:

- ТОГТООХ НЬ:** Банкны удирдлагаас танилцуулсан дараах баримт бичгийг баталсугай:
 - “2025 оны Бизнес төлөвлөгөө”-г энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасны дагуу баталсугай;



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
11 дүгээр сарын 01-ний өдрийн 30 тоот тогтоол

НУУЦЛАЛТАЙ

- “2025 оны Санхүүгийн төсөөлөл”-г энэхүү тогтоолын Хавсралт №2-т заасны дагуу баталсугай;
- “2025 оны Капитал хөрөнгийн зардал”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №3-т заасны дагуу баталсугай.

2. ТОГТООХ НЬ: Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа-д энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ



Түдэв овогтой Дарьбум

Дашдаваа овогтой Хулан

Харада Ясунари

Цагаач овогтой Баатарсайхан

Кисабуро Иший

Жон Ло

Амарбаясгалан овогтой Тамир

Ханс Аарт Йончеванс

Батболд овогтой Амарсанаа.



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
11 дүгээр сарын 01-ний өдрийн 30 тоот тогтоол

НУУЦЛАЛТАЙ

- “2025 оны Санхүүгийн төсөөлөл”-г энэхүү тогтоолын Хавсралт №2-т заасны дагуу баталсугай;
- “2025 оны Капитал хөрөнгийн зардал”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №3-т заасны дагуу баталсугай.

2. ТОГТООХ НЬ: Гүйцэтгэх захирал хатагтай Р.Мөнхтуяа-д энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авах эрхийг олгосугай.

БАТЛАВ

Түдэв овогтой Дарьбум

Дашдаваа овогтой Хулан

Харада Ясүнари

Цагаач овогтой Баатарсайхан



Амарбаясгалан овогтой Тамир

Ханс Аарт Йонгеянс

Батболд овогтой Амарсанаяа